



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 6/6

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 13 нэрийн, нийт 141,339,378.89 (нэг зуун дөчин нэгэн сая гурван зуун гучин есөн мянга гурван зуун далан найман төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007009

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
07. дугаар тогтоолын хавсралт

**"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ (ш)	Нэг бүрийн үнэ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Дуудлагын худалдаагаар худалдах доод үнэ
					(төгрөг)	
1	Киа пронтер, 57-03 УНЗ	2010/05/15	1	14,444,999.99	14,444,999.99	1,500,000.00
Баруун ТТ -ийн дүн					14,444,999.99	1,500,000.00
2	УАЗ Фургон, 31-90 УНЗ	2011/10/31	1	19,150,000.00	19,150,000.00	2,500,000.00
Налайх ТТ -ийн дүн					19,150,000.00	2,500,000.00
3	УАЗ 2206, фургон, УБЕ 15-17	2009/03/31	1	6,861,352.43	6,861,352.43	2,000,000.00
4	Зил-130 портвой, 04-60 ТӨА	1978/01/01	1	3,949,090.91	3,949,090.91	600,000.00
5	Чиргүүл уртасгагч	2007/10/31	1	2,261,672.00	2,261,672.00	500,000.00
6	Авто чиргүүл 469	2012/04/27	1	800,000.00	800,000.00	200,000.00
7	Мотоцикл	2012/10/01	3	2,150,000.00	6,450,000.00	450,000.00
Зуунмод ТТ -ийн дүн					20,322,115.34	3,750,000.00
8	Хьюндай Портер, 66-74 УБИ	2007/04/20	1	5,570,000.00	5,570,000.00	1,000,000.00
Сонгинохайрхан ХҮТ -ийн дүн					5,570,000.00	1,000,000.00
9	Верна аксент, 94-13 УНЧ	2008/4/4	1	6,980,000.00	6,980,000.00	500,000.00
Чингэлтэй ХҮТ -ийн дүн					6,980,000.00	500,000.00
10	Форд транзит, 44-65 УНЕ	2011/11/30	1	7,000,000.00	7,000,000.00	1,500,000.00
11	Соната-6, 61-62 УБҮ	11/9/2009	1	32,326,200.00	32,326,200.00	2,000,000.00
12	Хьюндай Соната NF6, 77-66 УБИ	6/27/2017	1	28,937,590.91	28,937,590.91	1,000,000.00
13	УАЗ 3741фургон, 04-72 УБК	6/30/2004	1	6,608,472.65	6,608,472.65	1,000,000.00
Төвийн хэсгийн дүн					74,872,263.56	5,500,000.00
НИЙТ ДҮН					141,339,378.89	14,750,000.00
					(нэг зуун дөчин нэгэн сая гурван зуун гучин есөн мянга гурван зуун далан найман төгрөг наян есөн мөнгө)	(арван дөрвөн сая долоон зуун тавин мянган)